

ХОВД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022.12.02

Монгол улсын засгийн газрын болон УБЕГ-ын бодлого шийдвэрийг орон нутгийн түвшинд зохион байгуулж хэрэгжилтийг хангуулан төрийн албан хаагчдыг мэдлэг чадвартай, мэргэшсэн, сахилга хариуцлага, ёс зүйтэй байлгах, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй, чанарын өндөр түвшинд хүргэх, цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж иргэдэд тоон гарын үсэг олгох, иргэдийн бүртгэлийн байгууллагад хандах хандлагыг сайжруулахад гол зорилгоо болгон ажиллаа.

Монгол улсыг хөгжүүлэх үндсэн чиглэл, Алсын хараа 2050, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Цахимын багц хууль тэр тусмаа цахим гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангуулах, Улсын бүртгэлийн ерөнхий газрын стратеги төлөвлөгөө, Ухаалаг засаглал төслийн хүрээнд Улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулах иргэдэд үзүүлэх үйлчилгээг авилгагүй, хүнд сурталгүй, цаасгүй, зардалгүй байх ажлыг амжилттай хэрэгжүүлэн ажилласан.

Цахим гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангаж, цахим бүртгэлүүдийг орон нутгийн иргэдэд ойлгуулах, цахим хэрэглээг нэвтрүүлэхэд анхаарч бүртгэлийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран авах боломжийг иргэдэд хүргэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж холбогдох дээд байгууллагаас ирүүлсэн чиглэл зөвлөмжийг цаг тухай бүрд нь улсын бүртгэгч нарт хүргүүлэн ажиллаа.

ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

- 1.Иргэний бүртгэлийн чиглэлээр
- 2.ЭХЭУБ-ийн чиглэлээр
- 3.Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр
- 4.Хяналт шалгалтын чиглэлээр
- 5.Тоон гарын үсэг олгох ажлын талаар
- 6.Дотоод ажил, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн чиглэлээр
- 7. Төсөв санхүүгийн чиглэлээр
- 8. Эрх зүй, сургалт сурталчилгааны талаар
- 9. Цахим үйлчилгээ
- 10.Бусад үйл ажиллагаа

1.ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛ

1.1. Иргэний гэр бүлийн бүртгэлийн талаар:

2022 оны жилийн эцсийн байдлаар иргэний бүртгэлийн чиглэлээр нийт 23607 иргэнд үйлчилгээ үзүүлэн ажилласан байна.Үүнд:

1. Төрсний бүртгэлд тайлант онд 1587 иргэн төрж бүртгүүлснээс эрэгтэй 811 эмэгтэй 776 хүүхэд төрсөн байна.
2. Үрчлэлтийн бүртгэлээр -42
3. Овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэлээр-71
4. Эцэг тогтоосны бүртгэлээр- 66

5. Гэрлэсний бүртгэлээр -349 бүртгэснээс анхны -332, дахин- 17 иргэний гэрлэлтийг бүртгэсэн байна.

6. Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл -56 бүртгүүлснээс захиргааны журмаар 10, шүүхийн журмаар 46 гэр бүлийн цуцлалтыг бүртгэсэн байна.

7. Нас барсны бүртгэл 433- ийг бүртгэж нийт иргэний 8 төрлийн бүртгэлийн чиглэлээр 2604 бүртгэлийг сумдаас хүлээн авч мэдээллийн санд нягтлан шалган баталгаажууллаа.



1.2. Шилжилт хөдөлгөөний бүртгэлийн чиглэлээр:

2022 оны жилийн эцсийн байдлаар 2449 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл хийгдсэн байна. Үүнээс:

Улаанбаатар хот болон бусад аймгаас шилжин ирсэн 503 иргэн шилжин ирж бүртгэгдсэнээс, насанд хүрэгч 311, хүүхэд 192 иргэн байгаагаас аймгийн доторх шилжилт хөдөлгөөнд 878 иргэн, үүнээс 495 насанд хүрэгч, хүүхэд 383, бүртгэгдсэн байна.

Баг хоорондын шилжилт хөдөлгөөний бүртгэл 1068 хийгдсэн байна. Үүнээс насанд хүрэгч-539, хүүхэд -529 байна.

1.3. Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийн чиглэлээр:

Жилийн эцсийн байдлаар үндэсний энгийн гадаад паспорт авахаар хүсэлтээ ирүүлсэн иргэдээс 2321 иргэнд үндэсний энгийн гадаад паспорт олгосон.

Үүнээс 16 –аас доош 516 хүүхдэд гадаад паспорт олгож, насан хүрэгчдэд гадаад паспортыг 1805 иргэнд тус тус олгосон байна. Жилийн эцсийн байдлаар 1327 иргэний гадаад паспортыг хүчингүй болгосныг ангилбал:

Хуудас хугацаа дууссан -1213, гэмтээсэн -13, эцгийн нэр,өөрийн нэр сольсон-2, визний шаардлагаар /хугацаа дуусаагүй/-87 иргэн, техникийн шаардлагаар-1, хаяж үрэгдүүлсэн-11 паспортыг тус тус хүчингүй болгосон байна. Гадаад паспортын бүртгэлийн мэдээллийн санд Е дугаар нь шивэгдээгүй байсан 812 иргэний дугаарыг шивж орууллаа.

2022 оны 5 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн үндэсний энгийн гадаад паспортны эх нотлох баримт бичгийг цахимжуулж ажлын хүрээнд 1626 иргэний гадаад паспортны мэдүүлэгийг цахимжуулсан.

Ковидын нөхцөл байдлын улмаас БНХАУ-ын хил хаагдаж Байтаг, Булган боомтоод зорчих иргэдэд хил нэвтрэх үнэмлэх олгоогүй байна.

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд шаардагдах зургийг стандартын дагуу авч сурах, зургийн аппаратыг ашиглаж сурах, шаардлага хангасан зургийг бүртгэлийн программд хэрхэн оруулах ажлын талаар хийсэн онлайн сургалтанд гадаад паспортны бүртгэл хариуцсан улсын бүртгэгч, иргэний улсын ахлах бүртгэгч нар хамрагдлаа.

Энэ ажлын хүрээнд үндэсний энгийн гадаад паспорт хариуцсан улсын бүртгэгч, мэдээлэл технологийн ажилтан нартай хамтран гадаад паспорт захиалах иргэдийн хүсэлтийг бүртгэх, иргэний зургийг Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага /ИКАО/-ийн стандарт шаардлагын дагуу авч иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд оруулах ажлыг амжилттай эхлүүлээ.



1.4. Регистрийн дугаар өөрчилсөн талаар:

Жилийн эцсийн байдлаар регистрийн дугаар өөрчлүүлэх хүсэлт гаргасан иргэдэд холбогдох ХУБ-ийн дүгнэлтийг үндэслэн 33 иргэний регистрийн дугаарыг нь өөрчлөн УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газарт албан тоотоор хүргүүлэн шинээр олгосон регистрийн дугаарыг нь мэдээллийн санд баталгаажууллаа.

Шинээр олгосон регистрийн дугаараар цахим үнэмлэхээ сольж авах зөвлөлгөө өгсний дагуу дээрх иргэд холбогдох материалаа бүрдүүлэн ирснээр цахим үнэмлэхийг дахин олгож өглөө.

1.5. Бүртгэлд засвар өөрчлөлт оруулсан талаар

1. Ховд аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн дагуу 7 иргэнд холбогдох үрчилсний бүртгэлийг хүчингүй болгосон шийдвэрийг хүлээн авч засвар өөрчлөлтийн маягтыг бичиж , шүүхийн шийдвэр, албан тоотын хамт УБЕГ-ын Иргэний Улсын бүртгэлийн газарт хүргүүлэн үрчилсний бүртгэлийг нь хүчингүй болгож анхны бүртгэлд нь оруулсан.

2. Иргэний баримтын архивын журнал болон цахим архивын нотлох баримтаас зөрүүтэй, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд үг, үсгийн алдаатай тусгагдсан нийт 895 иргэний бүртгэлийг засвар өөрчлөлтийн бүртгэлээр мэдээллийн санд залруулан тусгалаа.

Үүнээс: ХУБ-ийн дүгнэлтээр төрсний бүртгэлийн мэдээллийн санд эцэг эхийн мэдээлэл оруулах -364 ,үндсэн санд ургийн овгийн засвар оруулах -201, оршин суух хаягийг мэдээллийн санд тусгах-185, овог, эцэг /эх/-ийн нэр, нэр,өөрчилсний бүртгэлд засвар оруулах-35, үрчилсний өмнөх бүртгэл оруулах -24, эцэг тогтоосны өмнөх бүртгэл оруулах-7, гэрлэлтийн төлөв засах-19, ХУБ-ийн дүгнэлтээр ургийн овог засах-11, архивын эх нотлох баримтанд зөрүүгүй ИУБ-11 маягтыг үндэслэн эцэг эхийн мэдээлэл оруулах -49 нийт 895 иргэний бүртгэлийг засвар өөрчлөлтийн бүртгэлээр мэдээллийн санд тус тус залрууллаа.

1.6. Нөхөн бүртгэлийн талаар

Нөхөн бүртгэлийн чиглэлээр дараах бүртгэлүүдийг архивын нотлох баримтаас нөхөн хуулбарлан албан тоотоор хүргүүлэн мэдээллийн санд оруулснаас :

- ХААТР-11-65 ш
- ХААТР-12 -2 ш
- ХААТР-14- 1ш
- ХААТР-15- 8 ш
- ХААТР-18 -2 ш нийт 78 ш маягтуудыг мэдээллийн санд нөхөн бүртгэлээр тусгуулан ажиллалаа.

Мэдээллийн санд нас барсны бүртгэл нь тусгагдаагүй, регистрийн дугаар олгогдоогүй, иргэдийн нас баралт бүртгэгдсэн бүртгэлийн дэвтрийн журнал, нас барсан тухай лавлагааг нь иргэний улсын бүртгэлийн газарт албан тоотоор хүргүүлэн 6 иргэнд тусгай сери бүхий регистрийн дугаар олгож нас барсан бүртгэлийг нөхөн оруулж өгсөн.

1.7. Иргэний үнэмлэх олголтын бүртгэлийн талаар

2022 оны жилийн эцсийн байдлаар 3750 иргэний цахим үнэмлэхний санд тулгаж баталгаажуулан хэвлүүлж эздэд нь олголоо. Үүнийг захиалгын ангиллаар харуулбал: 16 насанд хүрсэн -1274, 25 насны сунгалт -1006 , 45 насны сунгалт 968, дахин олголт 495, гадаадад биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хамрагдсан-7 тус тус олгосон байна.

Шинээр 16 нас хүрсэн иргэдийг иргэний шинэчилсэн бүртгэлд хамруулахдаа улсын бүртгэгч нарын хайнга санамсаргүй байдлаас ИУБ-31 маягтанд дээр гаргаж байгаа алдаан дээр онцгой анхааран ажиллаж 3 иргэний бүртгэлд хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр мэдээллийн санд засвар өөрчлөлт оруулан зөрчил арилган иргэдийг цахим үнэмлэхжүүллээ. Шинэчилсэн системд нэвтэрч орсноор иргэний

шинэчилсэн бүртгэлд анх удаа, 25,45 насны сунгалт хийлгэж буй иргэний хурууны хээ авах программ нь онлайн системд нэвтэрснээр ямар нэгэн зөрчил гарах явдал арилж байна.

Цаашид ийм алдааг дахин давтан гаргахгүй байх тал дээр нь анхаарч сумдын бүртгэгч нарт 2 удаагийн чиглэлийг хүргүүлэн ажилласан. Сумдаас бүртгэгдэн ирж буй биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн ИУБ -31 маягтыг хүлээн авч галиглан ИБ-н газарт жагсаалтаар сар бүр тогтсон хугацаанд нь хүргүүлэн хэвшсэн.Гээж үрэгдүүлсэн цахим үнэмлэхээ захиалах иргэдэд чирэгдэл үүсгэхгүйн тулд E-mongolia системд хандаж үнэмлэх захиалах зааварчилгаа өгсний дагуу 91 иргэнийг хамруулсан.

Сумдаас ирүүлж буй цахим үнэмлэхний тооцоог тухай бүр нь тулган шалгаж авснаар сар бүрийн 25 нд нягтлан бодогч, нярав нартай үнэт цаас ашигласны тооцоог хийж хэвшсэн.

1.8. Иргэний бүртгэлийн архивын чиглэлээр.

Иргэний бүртгэлийн архиваас 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 11476 лавлагаа гаргаснаас хууль хяналтын байгууллагад 1115, иргэдэд 7235, албан хэрэгцээнд 3126 лавлагаа олгож үйлчиллээ.

Улсын бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэд төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж, эх нотлох баримтыг бүрэн цахимжуулах эхэлснээр УБЕГ-ын нэгдсэн архиваас олгодог лавлагааг орон нутгаас олгож эхэлснээр иргэдийг чирэгдүүлэхгүй архивын үйлчилгээг үзүүлж эхэллээ

Иргэний баримтын архивын архивч нь жилийн эцсийн байдлаар иргэний 8 төрлийн бүртгэлээр сумдаас бүртгэгдэн ирж буй ИУБ-11 маягт-1587 ш, ИУБ-12-42 ш, ИУБ-13-71 ш, ИУБ-14-66 ш, ИУБ-15 -349 ш, ИУБ-16 -56 ш, ИУБ -18-433 ш, ИУБ-22- 1345 ш маягт, ИУБ-31- 3255 ш маягт, нийт – 7204 ш маягтуудыг архивт галгилан хувийн хэрэгт нь тус тус байршуулсан.

Хяналтын улсын байцаагч болон хэлтсийн иргэний улсын бүртгэгч нарт лавлагаа мэдээлэл, нөхөн бүртгэл, засвар өөрчлөлтийн бүртгэлд тусгуулах болон дүгнэлт гаргах шаардлагаар 1389 ширхэг хувийн хэрэг татан өгснөөс 1378 ш маягтыг буцаан байршуулж, 11 иргэний маягт хяналтанд байна.

Шүүх цагдаа хууль хяналтын байгууллагаас 410 иргэнд холбогдох архивын нотлох баримтыг эх хувиас нь хуулбарлаж хуулбар тэмдэг дарж холбогдох газарт нь хүргүүлсэн.

Бусад аймаг хотоос албан тоотоор ирүүлсэн маягт, шилжин ирсэн иргэдийн хувийн хэргийг тус тус бүртгэж архивт байршуулж, шилжин явсан иргэдийн хувийн хэргийг холбогдох аймгуудад нь албан тоотоор хүргүүллээ. Тус хэлтсийн нэгжүүдэд цахим үнэмлэх захиалсан, гэрлэсний бүртгэлд бүртгүүлсэн, нас барсны бүртгэлд бүртгүүлсэн иргэдийн холбогдох маягтуудыг харьяалагдах газарт нь жагсаалт үйлдэн хүргүүллээ.

Тус хэлтсийн архивын лавлагаа олгох эрх бүхий улсын бүртгэгч нь бүх төрлийн лавлагаануудыг олгож байгаа бөгөөд архивын эх нотлох баримтаас шүүхгүйгээр цахим программаас нотлох баримтыг нь тулган лавлагааг олгож иргэдэд чирэгдэлгүй хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлдэг давуу талтай боллоо.

Жилийн эцсийн байдлаар иргэний улсын бүртгэлийн тасгаас олгосон лавлагааг төрлөөр нь авч үзвэл:

<u>д/д</u>	<u>Лавлагааны төрөл</u>	<u>Иргэнд</u>	<u>Хууль хяналтын байгууллагад</u>	<u>Албан хэрэгцээнд</u>
1	Төрсний лавлагаа	2313	132	634
2	Үрчилсний	76	0	0
3	Овог, нэр өөрчилсний лавлагаа	160	5	2
4	Эцэг тогтоосны лавлагаа	85	0	1
5	Гэрлэсний бүртгэлийн лавлагаа	415	65	450
6	Гэрлэлт дуусгавар	14	1	75
7	Гэрлэлт бүртгэжгүй тухай	152	2	862
8	Нас барсны лавлагаа	395	20	59
9	Цахим үнэмлэхний лавлагаа	2660	524	900
10	1-р маягтын тоо /хүүхдийн тоо/	103	2	0
11	Төрөл садангийн лавлагаа	503	2	4
12	Оршин суугаа хаяг	267	362	92
13	Регистрийн дугаар өөрчилсний	76	0	1
14	Гадаад паспорт /анх удаа/	5	0	0
15	Гадаад паспорт /дахин/	1	0	0
16	Иргэний үнэмлэх бүртгэлгүй	0	0	1
17	Төрсний бүртгэлгүй	10	0	45
	Нийт	7235	1115	3126

Шүүх, цагдаа, прокурорын байгууллага, АТГ, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүсэлт албан тоотой 1115 иргэдийн иргэний бүртгэлтийн талаарх мэдээллийг цаг тухай бүр нь гарган хүргүүлсэн болно.

Улсын бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэд төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж, эх нотлох баримтыг бүрэн цахимжуулснаар УБЕГ-ын нэгдсэн архиваас олгодог лавлагааг орон нутгаас олгож эхэлснээр иргэдийг чирэгдүүлэхгүй архивын үйлчилгээг үзүүлж байна.

Иргэний баримтын архивын архивч нь жилийн эцсийн байдлаар иргэний 8 төрлийн бүртгэлээр сумдаас бүртгэгдэн ирж буй ИУБ-11 маягт-1587, ИУБ-12-42,

ИУБ-13-71, ИУБ-14-66, ИУБ-15 -349, ИУБ-16 -56, ИУБ -18-433, ИУБ-22- 1345 маягт, ИУБ-31- 3255, нийт – 7204 маягтуудыг архивт галиглан хувийн хэрэгт нь тус тус байршуулсан.


Хяналтын улсын байцаагч болон хэлтсийн иргэний улсын бүртгэгч нарт лавлагаа мэдээлэл, нөхөн бүртгэл, засвар өөрчлөлтийн бүртгэлд тусгуулах болон дүгнэлт гаргах шаардлагаар 1389 хувийн хэрэг татан өгч 1378 маягтыг буцаан байршуулж, 11 иргэний ИУБ маягт хяналтанд байна.

Шүүх цагдаа хууль хяналтын байгууллагаас 410 иргэнд холбогдох архивын нотлох баримтыг эх хувиас нь хуулбарлаж хуулбар тэмдэг дарж холбогдох газарт нь хүргүүлсэн.

Бусад аймаг хотоос албан тоотоор ирүүлсэн маягт, шилжин ирсэн иргэдийн хувийн хэргийг тус тус бүртгэж архивт байршуулж, шилжин явсан иргэдийн хувийн хэргийг холбогдох аймгуудад нь албан тоотоор хүргүүлээ.

Тус хэлтсийн нэгжүүдэд цахим үнэмлэх захиалсан, гэрлэсний бүртгэлд бүртгүүлсэн, нас барсны бүртгэлд бүртгүүлсэн иргэдийн холбогдох маягтуудыг харьяалагдах газарт нь жагсаалт үйлдэн хүргүүлээ.

Архивын сан хөмрөгийн баяжилтыг тухай бүрд нь хийж архивын байрны стандартыг ханган ажиллаж байна.





2.ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ

2.1. Хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

2022 оны жилийн эцэсийн байдлаар иргэн, хуулийн этгээдээс нийт 5934 мэдүүлэг хүлээн авч 5764 мэдүүлэгт бүртгэл хийж 170 мэдүүлгийг нотлох баримтын шаардлага хангуулахаар буцаан ажилласан байна.



Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн нийт 3126 мэдүүлэг хүлээн авч бүртгэл хөтөлсөн байна.

Шинээр баригдсан орон сууц өмчлөх эрхийг анх удаа бүртгэл:169

ГБҮХЭХӨЭАУБүртгэх:264

Барьцааны гэрээ:2175

Үенч:16	Мөст:4
Манхан:56	Мөнххайрхан:2
Дуут:6	Булган:27
Мянгад:19	Дөргөн:9
Чандмань:22	
Эрдэнэбүрэн:15	

Газар өмчлөх эрх:

Алтай: 9	Зэрэг:34
Буянт:91	Цэцэг:4
Дарви:14	Ховд:19
Үенч:8	Мөст:5
Манхан:66	Мөнххайрхан:8
Дуут:10	Булган:20
Мянгад:22	Дөргөн:10
Чандмань:12	
Эрдэнэбүрэн:21	

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжээс иргэдэд чирэгдэлгүй хүргэх зорилгоор Ховд аймгийн Булган, Цэцэг, Мөнххайрхан сумдын улсын бүртгэгч нарт Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар эд хөрөнгийн бүртгэл хөтлөх эрх олгосоны дагуу тус сумдын бүртгэгч нарын ажил үүргийн хуваарийг хийж 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс 14-ны өдрийн хооронд ажлын 5 хоногийн хугацаанд хэлтэс дээр дадлагажуулан ажилласан.Тус сумдын улсын бүртгэгч нар тойргийн сумууд болох Алтай, Үенч, Мөст, Дуут, зэрэг сумдын эд хөрөнгийн эрхийн бүртгэлийг бүртгэн ажиллаж байна.

2022 оны 02 дугаар сарын 22-24-ны хооронд Алтай, Үенч, Булган, Мөст, Цэцэг зэрэг 5 суманд хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсэг ажиллаж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгосон бүртгэгч нарын техник тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, мэдээллийн санд нэвтрэх, мэдээллийн сантай ажиллах тал дээр арга зүйгээр хангаж, бүртгэлийн явцтай танилцаж, заавар зөвлөгөө өгч, иргэдэд нөлөөллийн арга хэмжээ авч ажилласан.

Эрх олгогдсон 3 сумдын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг тоон байдлаар харуулвал:

Булган сум - 537

- ❖ ГБҮХЭХӨЭАУБүртгэх-42
- ❖ Төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг анх удаа бүртгэх-113

- ❖ Барьцааны гэрээ-171
- ❖ Барьцааны гэрээ дуусгавар болгох-84
- ❖ Өмчлөх эрх шилжих бүртгэл-117

Цэцэг сум - 41



- ❖ ГБҮХЭХӨЭАУБүртгэх-7
- ❖ Төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг анх удаа бүртгэх-14
- ❖ Барьцааны гэрээ-9
- ❖ Барьцааны гэрээ дуусгавар болгох-2
- ❖ Өмчлөх эрх шилжих бүртгэл-9

Мөнххайрхан сум – 18

- ❖ ГБҮХЭХӨЭАУБүртгэх-2
- ❖ Төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг анх удаа бүртгэх-5
- ❖ Барьцааны гэрээ-1
- ❖ Барьцааны гэрээ дуусгавар болгох-0
- ❖ Өмчлөх эрх шилжих бүртгэл-7 тус тус бүртгэсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг нь тайлант оны 10.01-ны өдрөөс газар болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн нийт 19400 гаруй хувийн хэргийн нотлох баримтыг мэдээллийн сантай тулган шалгах ажлыг эхлүүлэн 11.25-ны өдрийн байдлаар 1400 орчим хувийн хэргийг шалгасан байна.

Үүнээс 304 зөрчил илрүүлэн эд хөрөнгийн эрхийн мэдээллийн санд засвар хийж ажилласан ба сар бүр тайланг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлэн ажиллаж байна.



Тайлангийн жилийн хугацаанд Эд хөрөнгийн улсын бүртгэлийн мэдээллийн санд өмчлөгчийн мэдээлэл, эд хөрөнгийн мэдээлэл болон зарим нотлох баримт буруу, дутуу цахимжсан 245 хувийн хэргийг хяналтын улсын байцаагчийн 1500 дугаартай дүгнэлтийг үндэслэн засвар өөрчлөлт хийж ажиллаа.

Бүртгэгчийн алдааны улмаас 5 хувийн хэрэгт засвар өөрчлөлт оруулахаар дүгнэлт гарсаныг засварлаж ажилласан ба 2022 онд нийт 549 хувийн хэргийн зөрчил арилгаж ажилласан байна.



МИК-ийн Хаан банк, Хас банк, Голомт банк, Капитрон банк, Төрийн банкуудтай хийсэн үнэт цаас “Худалдах худалдан авах гэрээ”, албан хүсэлтийг үндэслэн 167 иргэний хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд тусгай тэмдэглэл хийсэн байна.



Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/244 тоот ажлын хэсэг байгуулах тушаалын мөрөөр “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэгт

үзлэг хийх ажлын удирдамж гаргаж ирүүлсний дагуу Буянт сумын ү1603000001-ү1603000040, Ховд сумын ү1613000017-ү1613000060 хүртэлх нийт 200 хувийн хэрэгт үзлэг дүн шинжилгээ хийж ирүүлсэн хүснэгтийн дагуу шалгаж хугацаанд нь “ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР”-т хүргүүлэн ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын А/429 тоот "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх мэдүүлэг, маягтын загварыг шинэчлэн батлах тухай" тушаалыг хэрэгжүүлэн шинэчлэгдсэн мэдүүлэг маягтыг бүртгэлийн үйл ажиллагаандаа хэрэглэж хэвшлээ.


Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын А/427 тоот тушаалын дагуу “Барьцааны гэрээ /ипотек/-г эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт /ЭУБ-06 маягт/, “Барьцааны гэрээ /ипотек/-ний нэмэлт, өөрчлөлтийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт /ЭУБ-13 маягт/-ын дагуу 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн барьцааны гэрээг улсын бүртгэлд бүртгэж эхлээд байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2022.11.08-ны өдрийн хугацаатай үүрэг өгөх тухай албан бичгийн дагуу Ховд аймагт хамаарах “Эд хөрөнгийн хэмжээ тусгагдаагүй 9”, “Эд хөрөнгийн үнэ ороогүй 66”, “Газрын нэгж талбарын дугаар ороогүй 3”, “Барьцаалагчийн мэдээлэл алдаатай 135” нийт 213 хувийн хэргийн зөрчлийн арилгаж хугацаанд нь холбогдох газарт ИЛТГЭХ ХУУДАСыг хүргүүлэн ажиллаа.




2022 оны жилийн эцсийн байдлаар Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай дундын мэдээллийн сангаар дамжуулан /Э/ дугаар 1981, /А/ дугаар 6-г тус тус олгож ажилласан байна.

Газар болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэлийг сүүлийн 3 жилээр харьцуулан харуулбал:



Гэрээ эрхийн бүртгэлийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:



2.4. Хууль хяналтын байгууллагыг холбогдох мэдээллээр хангаж ажиллах ажлын хүрээнд:

Хууль хяналтын байгууллагуудыг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд лавлагаа мэдээллээр хангаж ажилладаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 87 удаагийн албан бичгээр 187 иргэн, Хуулийн этгээдийн лавлагаа мэдээллийг



Авилгатай тэмцэх газрын 36 удаагийн албан бичгээр 64 иргэн Хуулийн этгээдийн лавлагаа мэдээллийг



Цагдаагийн газрын 232 удаагийн албан бичгээр 269 иргэн, Хуулийн этгээдийн лавлагаа мэдээллийг



Шүүхийн байгууллагын 4 удаагийн албан бичгээр 13 иргэн, Хуулийн этгээдийн лавлагаа мэдээллийг



Татварын хэлтсийн 5 удаагийн албан бичгээр 69 иргэн, Хуулийн этгээдийн

Төрийн бусад байгууллагын 8 удаагийн албан бичгээр 9 иргэн, Хуулийн этгээдийн лавлагаа мэдээллийг тус тус хүргүүлэн ажиллаа.

2.5. ЭХЭУБ-ийн архивын талаар.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн архивт 2022.11.25-ны өдрийн байдлаар нийт 30123 хувийн хэрэг хадгалагдаж байна.

Газар эзэмших эрхийн-10682

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн-9991

Жаргалант сумын-7470

Сумдын-2521

Газар өмчлөх эрхийн -9450

Жаргалант сумын-5212

Сумдын-4238

Мөн сар бүрийн мэдээ тайланг ePRS-2 системээс газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн мэдээ, Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн мэдээ, мэдээллийн санд засвар өөрчлөлт хийсэн тухай тэмдэглэл, орон сууц, хувийн сууцны анхны бүртгэл болон өмчлөх эрх шилжсэн талаарх мэдээ, орон сууцны барьцааны мэдээ зэргээр гарган тухайн сарын 25-ны өдрийн дотор Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлэн ажиллаж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 4 удаагийн чиглэлийг тасгийн бүртгэгч нарт тухай бүр танилцуулан өдөр тутмын бүртгэлийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.



3. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛ:

3.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр.

Хуулийн этгээдийн улсын бүртгэл нь 2022 онд хэлтсийн үйлчилгээний нэгдсэн зааланд байршин бүртгэлийн үйл ажиллагаагаа явуулж аймгийн төв, хөдөөгийн 16 сумын иргэд, хуулийн этгээдүүдэд үйлчилгээ үзүүлж ажиллалаа.


Хуулийн этгээд байгуулах зорилгоор ирсэн 1170 гаруй иргэн болон хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтанд улсын бүртгэлтэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгч, программ дээр 1232 гаруй нэр шүүж үүнээс 538 нэрийн баталгаажуулалт хийв. Мөн e-mongolia системээр 799 оноосон нэрийн хүсэлт ирснийг цаг тухай бүрт шийдвэрлэж ажилласан.

Тайлангийн хугацаанд хязгаарлагдмал хариуцлагатай компани 240, нөхөрлөл 2, хоршоо 40, Холбоо /төрийн бус байгууллага/ 17, үйлдвэрчний эвлэлийн байгууллага 4, сан-1 нийт 304 хуулийн этгээдийг шинээр бүртгэж гэрчилгээ олгов.

Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг өнгөрсөн 3 жилийн мөн үетэй харьцуулбал:

Д/д	Хуулийн этгээдийн хэлбэр	2019 он	2020 он	2021он	2022 он	2022 оныг 2019 онтой харьцуулсан өсөлт, бууралт	2022 оныг 2020 онтой харьцуулсан өсөлт, бууралт	2022 оныг 2021 онтой харьцуулсан өсөлт, бууралт
1	ХХКомпани	129	153	187	240	+111	+87	+53
2	ОНӨААТҮГазар	2	1	3		-	-	-
3	Нөхөрлөл	11	12	42	2	-9	-10	-40
4	Хоршоо	7	8	4	40	+33	+32	+36
5	Төсөвт газар	4	1	1		-	-	-
6	ТБ байгууллага	15	33	15	17	+2	-16	+2
7	ҮЭ Байгууллага	1	16	5	4	+3	-12	-1
8	Сан	3	1		1	-2	1	-
9	Шашны байгууллага		3	2		-	-	-
10	Дүн	159	172	228	304	+138	+81	+50

Шинэ бүртгэлийг графикаар харуулбал:



Хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтны хүсэлтээр 432 хуулийн этгээдийн бүртгэлд өөрчлөлт хийж, 16 хуулийн этгээдийн салбарын бүртгэл хийж гэрчилгээг бичиж олгов. Нэр өөрчилсөн, хэлбэр өөрчилсөн, гэрчилгээгээ гээгдүүлсэн болон гэрчилгээ нь шаардлага хангахгүй болсон хуулийн этгээдийн удирдлагын хүсэлтээр 88 хуулийн этгээдэд дахин гэрчилгээ олгов.

Шинээр байгуулагдсан 304 хуулийн этгээдийн хувийн хэргийг дугаарлан хавтаслаж, цахимжуулан архивт маягтаар хүлээлгэн өгсөн ба өөрчлөлт болон хуулбар, лавлагаа хийгдсэн 543 хуулийн этгээдийн нотлох баримт материалыг цахимжуулан маягтаар архивт хүлээлгэн өгч ажиллалаа.

Шинээр байгуулагдсан 304 хуулийн этгээд, бүртгэлд өөрчлөлт оруулсан 230 хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн бүртгэлийг хийлээ.

Орон нутгийн төсөвт улсын бүртгэлтэй холбоотой тэмдэгтийн хураамж 17992,0 мянган төгрөгийн орлого оруулж хуулийн этгээдийн архивын хуулбар болон нэрийн баталгаажуулалтын орлого 16004,0 мянган төгрөгийг байгууллагын төсвийн дансанд орууллаа.

Тайлангийн хугацаанд 383 хуулийн этгээдэд байгууллагын тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх хяналтын дугаар олгож, хуулийн этгээдийн нэр өөрчлөгдөж солигдох болон гэмтээсэн 39 ширхэг тэмдгийг хураан авч, архивт хүлээлгэн өгсөн.

Сар бүрийн мэдээг цаг тухай бүрт нь гаргаж, хэлтсийн дарга, аймгийн засаг дарга болон холбогдох удирдлагуудыг мэдээ, мэдээллээр хангаж, сар бүрийн мэдээ, холбогдох тайланг хугацаанд нь гаргаж дамжуулж ажиллалаа.

Аймгийн ЗДТГазрын санхүүгийн хяналт, аудитын газар, шүүх, цагдаагийн газар, татварын хэлтэст албан хүсэлтийн дагуу лавлагаа, судалгааг тухай бүр гаргаж хүргүүлээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон Жижиг дунд үйлдвэрийн газраас 4 сарын 7,8-нд зохион байгуулсан “Хоршоодын шинэчилсэн бүртгэл зохион байгуулах арга зүйн зөвлөгөө өгөх” тэнхимийн сургалт, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас 05 дугаар сарын 26-нд зохион байгуулсан онлайн сургалт “ХЭУБГ-ын дотоод үйл ажиллагаанд чиглэл, зөвлөмж, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, анхаарах асуудал” сэдвээр, мөн онлайн сургалтуудад тухай бүр хамрагдсан.

Хуулийн этгээдийн бүртгэлийн орлогын мэдээ, үнэт цаасны зарцуулалтын тайланг сар бүр гаргаж, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ 304, салбарын гэрчилгээ 16, зарцуулж, санхүүтэй тооцоо хийж үнэт цаасны зөрчилгүй ажиллалаа.

Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас авсан шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй байгаа хуулийн этгээдийн судалгааг гаргаж, ахлах бүртгэгчид хүргүүлэв. Мөн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 1/3681 тоот чиглэл зөвлөмжийн дагуу Эцсийн өмчлөгчийн мэдээллээ бүртгүүлээгүй байсан 1250 аж ахуйн нэгж рүү холбогдож бүртгүүлэх талаар мэдээлэл хүргэн ажилласан. Уг ажлын биелэлтийн тайланг цаг хугацаанд холбогдох дээд газарт хүргүүлээ.

Хайрлая, хүндэлье, хандлагаа өөрчилье аяны хүрээнд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн хамт олонтой хамтран 2020.03.30-ны өдөр Их буян зах дээр ажиллаж хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан бөгөөд 04 дүгээр сарын 26-ны өдөр Аймгийн залуучуудын холбооноос зохион байгуулсан арга хэмжээнд Холбоо /төрийн бус байгууллага/, “Хоршоо шинээр байгуулахад анхаарах зүйл” сэдвээр холбогдох мэдээлэл хийлээ. Мөн аймгийн хоршоологчдын холбоо, татварын хэлтэс, хөдөө аж ахуйн газар, хоршоодын удирдлагуудтай хоршооны асуудлаар уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд уг хэлэлцүүлэг сургалтад мэдээлэл өгч оролцлоо. .

Түүнчлэн Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан “Шашны асуудал эрхэлсэн зөвлөл”-ийн бүрэлдэхүүнд оролцож, 06 сарын 27, 10 сарын 31-нд, 2 удаа хуралдаж, 2022 оны зөвлөлийн ажлын төлөвлөгөө болон хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө баталж, аймгийн иргэдийн хуралд оруулах санал болон цаг үеийн асуудлаар хэлэлцэв. Мөн 2022 оны 11 дүгээр сарын 08 -нд тус зөвлөл нь Булган, Үенч сумдад хяналт шалгалтаар ажиллалаа.

3.1. Хуулийн этгээдийн архив

Тус хэлтсийн бичиг баримтын архивт хуулийн этгээдийн 3697 хувийн хэрэг байршиж байна.

Хувийн хэргүүдийн баяжилт хөдөлгөөнийг тухай бүрд нь хийж хэвшсэн бөгөөд хууль журмын хүрээнд хувийн хэргээс хуулбар олгох, лавлагаа мэдээлэлийг ААН, хуулийн этгээдийн хүсэлтээр шуурхай олгож байна.



4. Хяналт шалгалтын чиглэлээр

Тус хэлтэс нь тайлангийн хугацаанд хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг тус тус гарган батлаж сумдын бүртгэлийн үйл ажиллагаа, мөн хэлтсийн Иргэн, ЭХЭУБ, Хуулийн этгээдийн бүртгэл, Архивын үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж төлөвлөгөөт болон түүвэрчилсэн шалгалтыг хийж бүртгэлийн зөрчлийг тухай бүрд нь арилгуулан ажиллаж байна. Төлөвлөгөөт шалгалтыг 288 бүртгэл дээр, гүйцэтгэлийн шалгалтыг 189 бүртгэл дээр тус тус хийсэн.

Хяналт тавьсан бүртгэлийг ангилж үзэхэд:

1. Хяналт тавьсан бүртгэлийн тоо – 413, Үүнээс:

А.Иргэний бүртгэлийн чиглэлээр – 176

* ЭХЭУБ-ийн чиглэлээр - 165

* Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр – 47

* Улсын бүртгэлийн архивын чиглэлээр - 25

2. Илрүүлсэн нийт зөрчил - 29

* ***Иргэний бүртгэл – 23***

* ***ЭХЭУБ - 6***

А. Эрх бүхий хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн - байхгүй

Б. Шалгалтын явцад шийдвэрлэсэн зөрчлийн тоо – байхгүй.

В. Хүчингүй болгосон бүртгэлийн тоо - 4

В. Зөрчлийн хуулиар торгох шийтгэл оногдуулсан иргэн хуулийн этгээдийн тоо - 1095

3.Оногдуулсан торгуулийн хэмжээ 23,260,000 төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлсэн байна.



Хэлтсийн хэмжээнд 3 бүртгэлийн чиглэлээр иргэдээс ирүүлж буй материал хүлээн авалт, бүртгэл хөтлөлтийн дэвтэр, өдөр тутмын бүртгэлийг түүвэрчлэн хянаж шалгаж арга зүйн зөвлөгөө мэдээллийг өгч ажиллаж байгаагаас гадна ЭХЭУБ нарын өдөр тутмын бүртгэл, анхны бүртгэл, барьцаат зээлийн гэрээний бүртгэлийн бүрдүүлсэн нотлох баримт, ePRS программд бүртгэл хөтөлсөн байдал зэрэгт хяналт тавьж зөвлөн туслаж байна.

Даргын зөвлөлийн хурлын шийдвэрээр сумдын бүртгэгч нарын бүртгэсэн бүртгэлийн эх нотлох баримтыг татан авч шалгаж, нэгжийн бүртгэгч нарт арга зүйн зөвлөгөөг тухай бүрд нь өгч ажиллаа.

Сар бүрийн мэдээ тайланг холбогдох дээд байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.

5. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган

ажилласан талаар

Улсын бүртгэлийн байгууллагаас Монгол Улсын 16 насанд хүрсэн иргэдэд тоон гарын үсэг олгох эхлэхтэй холбоотой ажлын нээлт, тоон гарын үсэг олгох ажлыг амжилттай зохион байгуулан ажиллаж 2022 оны жилийн эцсийн байдлаар 17726 иргэд буюу нийт ТГҮ авах нийт иргэдийн 30%-ийг хамруулан тоон гарын үсгийг нь олгож иргэний үнэмлэхний санах ой, гар утсанд нь суулгалаа.

Хууль хэрэгжиж эхэлсэн 2022 оны 05 сарын 02-нд Ховд аймгийн Малчдын зөвлөгөөнд оролцож буй хөдөөгийн малчдад Тоон гарын үсгийн талаар нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж Монголын Үндэсний ТВ болон орон нутгийн ТВ-ээр иргэдэд мэдээлэл өгсөн.



Мөн сумдын бүртгэгч нарт хугацаатай үүрэг даалгавар хүргүүлж, шторк бэлдүүлэн орон нутгийн мэдээллийн сайтуудаар иргэдэд хүргүүлэх арга хэмжээг зохион байгууллаа.

Цахим гарын үсгийн тухай хуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийн талаар “Монгол Улсын 16 насанд хүрсэн иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмын танилцууллага, “Цахим гарын үсгийн тухай хуулиар Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийн талаар”, “Тоон гарын үсэг хэрхэн олгох талаар хэлтсийн дарга, ИУБ-ийн тасгийн дарга нар хэлтсийн албан хаагчдад болон сумдын улсын бүртгэгч нарт сургалт мэдээлэл хийлээ.




Хөдөөгийн сумдын улсын бүртгэгч нарыг ТГҮ ажилд дадлагажуулах ажлыг аймгийн төвийн Жаргалант суман дээр зохион байгуулж арга зүйгээр ханган ажилласан.




Иргэдэд тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд хөдөөгийн бүх сумдыг 2 удаа тойрч ажилласан бөгөөд үйл ажиллагаа сурталчлах, тоон гарын үсэг олгох ажлуудыг сумдад зохион байгуулж иргэдэд нөлөөллийн арга хэмжээ авах, соён гэгээрүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Мөн дээрхи ажлын хүрээнд УИХ-ын гишүүн С. Бямбацогтын ажлын албатай хамтарч бүх сумдын иргэдэд “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулж, үйл ажиллагаа сурталчлах, ТГҮ олгох ажлыг хийлээ.



Энэ ажилд Булган, Дарви, Цэцэг, Ховд, Эрдэнэбүрэн сумдууд бусад сумуудаа хошуучлан оролцож ажиллаа.





Улсын бүртгэгч нар нь ээлжийн амралттай, жирэмсний амралттай, 4 суманд хэлтсийн ИУБ-ийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Эрдэнэбулганаар ахлуулсан ажлын хэсэг очиж ажиллаа.




Үенч сумын ХЦ-ийн 130 дугаар анги болон алслагдсан заставуудаар 5 өдөр ажиллаж цэрэг, ахлагч нар, офицеруудыг болон тэдний гэр бүлийг тоон гарын үсэгт хамруулах ажлыг зохион байгуулж Булган Үенч сумдын улсын бүртгэгч нар, хэлтсийн ажлын хэсгийнхэн явж ажиллаа.

Энэ үеэр цэрэг, ахлагч нар, офицерууд, тэдний гэр бүлд мэдээлэл өгч, гарын авлага материал тарааж хууль журам сурталчлах ажлуудыг хийсэн.

Мөн ЗХ-ний 123 дугаар ангид очиж ажилласан бөгөөд ТГҮ олгохоос гадна мэдээлэл өгч ажилласан.



Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд аймгийн төвийн бүх албан газраар явж ТАХ нарыг тоон гарын үсэгт хамруулах ажил зохион байгууллаа.



6. Дотоод ажил, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн чиглэлээр.

Тайлант оны 1 дүгээр улиралд хэлтсийн төрийн захиргааны албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулж хүргүүллээ.

Улирал бүр төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд явцын хяналт хийж, үр дүнг тооцож хэвшсэн.

Байгууллагын ажилтнуудын цаг ашиглалт, өдөр тутмын үйл ажиллагаанд хэлтсийн даргын зөвлөлийн бүрэлдэхүүн байнгын хяналт тавин ажиллаж гарсан асуудлыг тухай бүрд нь шийдвэрлэдэг.

Байгууллагаас гарч буй бүхий л мэдээ мэдээллийг цаг тухай бүрд нь байгууллагын вэб сайтад байршуулж ажилласан.

Орон нутгийн ТВ, хэвлэл мэдээллийн байгууллагаар өөрийн байгууллагын үйл ажиллагааны талаар тогтмол мэдээлж байдаг, 2022 онд 5 удаа үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлэлийг Khovd TV болон Khovd NEWS.MN сайтад тавьж хийж хэрэгжүүлсэн буюу цаг үеийн ажлуудыг тухай бүрд нь мэдээлж ажилласан. Мөн байгууллагын мэдээллийн самбарт иргэдэд чиглэсэн мэдээ мэдээллийг байнга байршуулж тавьдаг.

Тайлант онд Улсын бүртгэлийн хэлтсийн 70432888 утсаар 159 иргэний хүсэлт саналыг сонсож 38 яаралтай асуудлуудыг шуурхай шийдвэрлэж ажилласан бөгөөд 121 иргэдэд арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

БНШАЗК-ын ажлын төлөвлөгөөг баталсан. 2022 оны 2 сард байгууллагын БНШК хуралдаж зөвлөмж гаргасан. Мөн хугацаа дууссан актлах жагсаалтад орсон 22 нэр төрлийн 11549 материалыг Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газрын 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн зөвлөмж чиглэлийн дагуу устгах ажлыг зохион байгуулж, тайланг холбогдох газарт хүргүүлсэн. Тус хэлтсийн иргэний баримтын архивт хадгалагдаж байгаа 2022 онд хадгалах хугацаа дууссан мэдээлэл лавлагаанд ашиглах боломжгүй 15 нэр төрлийн 3220 устгах баримт бичгийн саналын жагсаалтыг улсын бүртгэлийн нэгдсэн архивын газарт хүргүүллээ.



2022 оны жилийн эцэст 365 иргэний өргөдөл ирсэнээс 343 нь шийдвэрлэгдэж, 22 өргөдөл нь хугацаа болоогүй хүлээгдэж байна.

- Иргэний бүртгэлийн чиглэлээр- 356
- Албан хаагчдаас ирүүлсэн хүсэлт- 5

- Хуулийн этгээдийн чиглэлээр – 1
- ЭХЭУБ-ийн чиглэлээр – 1
- Бусад - 2

Өргөдөл гомдлын мэдээг сар бүр хууль журамд заасан хугацаанд хүргүүлэн ажиллаа.

Хэлтсийн албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн эргэлтэнд хяналт тавьж 2022 оны эцсээр ирсэн 1033, явсан 1308, хугацаатай 145 бичгийг хяналтанд аван ажиллаа.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн А-6, Б-10 тушаалыг хяналтад авч бүртгэл хөтлөн хэрэгжилтийг ханган үүрэг чиглэлийн биелэлтийг тооцон ажиллаа.

Тайлант онд даргын зөвлөлийн хурлыг 6 удаа, хэлтсийн ажилтнуудын шуурхай хурлыг 20 удаа зохион байгуулан ажилласан.



7.Төсөв санхүүгийн чиглэлээр

2022 онд байгууллагын өмч хөрөнгийн тооллогыг хийх комисс байгуулж эд хөрөнгийн болон үнэт цаасны тооллого хийж, ашиглагдах хугацаа нь дууссан, ашиглах боломжгүй тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж актлуулах саналаа Санхүү аж ахуйн хэлтэст хүргүүлсэн.

Батлагдсан төсвийг зүйл заалтаар нь үр дүнтэй захиран зарцуулж, хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь үнэн бодитой тайлагнан ажиллаж 11 дүгээр сарын 25-ны байдлаар 130 мэдээллийг хугацаанд нь мөн төсөв хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээ мэдээллийг хэлтсийн вэб сайт болон санхүүгийн мэдээллийн самбарт байршуулж хэвшсэн ба шилэн дансны хуулийг мөрдөн ажиллаа.

2022 оны санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулж санхүүгийн зөрчилгүй ажиллаа.

Хэлтсийн дарга, ахлах ня-бо нар сангийн яамнаас орон нутагт зохион байгуулсан сургалтанд хамрагдаж тоон гарын үсгээр ажилтнуудын цалинг шууд сангийн яам руу шивж, баталгаажуулж төрийн сангаар цалингийн дамжихгүй байх үйл ажиллагаанд шилжсэн.

Сумдын бүртгэгч нарын үнэт цаасны тооцоог тухай бүр нь хийж, орлогын мэдээг сар бүрийн 25-ны дотор авч байна.

8. Эрх зүй, сургалт сурталчилгааны талаар

Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системээр 24 удаагийн сургалтанд хамрагдаж, 1 удаагийн судалгааг хийсэн. Дээрхи сургалтанд хамрагдсан албан хаагчид үнэлгээгээ өгсөн болно.

Мөн дээрхи програмаар Монгол бичгийн 1 шатны хичээлд 20 албан хаагч, ИУБ-ийн 1 шатны хичээлд 19 албан хаагч, ЭХЭУБ-ийн 1 шатны хичээлд 6 албан хаагч тус тус хамрагдсан.


Мөн хэлтсийн сургалтын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж 18 удаагийн сургалтыг зохион байгуулж, 40 ажилтан, 756 иргэдэд нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

Мөн ТА-ны зөвлөлөөс зохион байгуулдаг 7х4х10-ын пүрэв гарагийн 30 удаагийн сургалтанд хэлтсийн нийт албан хаагчид хамрагдаж мэдлэг мэдээллээ дээшлүүлсэн.

Ингэснээр улсын бүртгэлийн байгууллагын ажилтан албан хаагч, улсын бүртгэгч нарыг чадавхжуулах ажил үе шаттайгаар хэрэгжиж байна.



Хөдөөгийн сумдын улсын бүртгэгч нарт танхимын сургалтыг 2 удаа, цахимаар 9 удаа зохион байгуулж тулгамдаж буй ажлуудыг тухай бүрд нь шийдвэрлэн ажиллаа.



Хэлтсийн нийт албан хаагчдад Норвегийн тусламжийн байгууллагын суурин төлөөлөгчөөр “Эерэг хандлагыг хэрхэн үүсгэх”, “Харилцаа хандлага ба эсрэг сэтгэлгээ” сэдвээр сургалт, Аймгийн засаг даргын тамгын газрын хууль эрхзүйн хэлтсийн ахлах мэргэжилтэнээр хэлтсийн сургалтын төлөвлөгөөний дагуу

“Авилгаас урьдчилан сэргийлэх” сэдвээр хэлтсийн алба хаагчдад сургалт зохион байгууллаа.



Жендэр, ГХУС, Авлигын эсрэг, Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг, бичиг хэргийн талаар, Цахим үйлчилгээний чиглэлээр төв, орон нутгаас хийсэн 16 удаагийн сургалтуудад холбогдох албан тушаалтнууд бүрэн хамрагдлаа.




Хэлтсийн хамт олонд 2022 оны 03 сарын 28-ны өдөр Хувь хүний хөгжлийн баруун бүсийн институтын захирал Б.Гантогоог урьж “ Аз жаргалтай амьдрал ” сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан.

Америкийн нэгдсэн улсын консулын газрын албан хаагчдаар 2022.06.08-нд “Гадаад паспорт болон бусад хуурамч бичиг баримтыг хэрхэн таних, хуурамч бичигт баримтанд шинжилгээ хийх багажийг хэрхэн ашиглах” талаар сургалт авч танилцуулга хийлгүүлсэн.



Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар болон Барилга хот байгуулалтын яамны хамтарсан р “Барилга байгууламжийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх явцад тулгарч буй асуудал” сэдвээр сургалтыг 2022.11.25-нд зохион байгуулсан сургалтанд онлайнаар оролцож мэдээ мэдээлэл авсан.



Мөн орон нутгаас зохион байгуулдаг сургалтууд холбогдох албан хаагчид оролцож байна.

ХЗДХЯ-ны системийн байгууллагуудтай нягт уялдаатай ажиллаж сургалт сурталчилгааны олон ажлуудыг зохион байгууллаа.



9. Цахим үйлчилгээний талаар.

17 сумдын иргэдэд E-mongolia төрийн үйлчилгээний талаар сургалт сурталчилгааг тасралтгүй хийж ажиллаа. Үйлчилгээний зааланд мэдээлэл өгөх үйл ажиллагааг ТВ дэлгэцээр байнгын явагдаж байна. Жилийн эцсийн байдлаар E Mongolia цахим системээс 799 иргэн Хуулийн этгээдийн нэрийн баталгаажилт хийлгэж 91 иргэн иргэний үнэмлэх , 52 иргэн гадаад паспорт захиалж нийт 942 иргэн үйлчилгээ авсан байна.

Аймгийн төв дээр E-Mongolia цахим үйлчилгээ сэдэвт Нээлттэй хаалганы өдөрлөгийг аймгийнхаа 45 албан газруудтай хамтран зохион байгуулж 156 иргэнд мэргэжил арга зүйн болоод цахим гарын үсгийн, цахим үйлчилгээний талаар мэдээ мэдээлэл өгч ажилласнаас гадна аймгийн нийт худалдаа үйлчилгээ эрхэлж буй 232 хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд e mongolia системд хэрхэн хандаж үйлчилгээ авах чиглэлээр мэдээлэл өгч гарын авлага материалаар хангаж 13 иргэнд гадаад паспорт, 9 иргэнд цахим үнэмлэхийг цахимаар захиалсан



Ховд аймагт E-mongolia цахим системийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлах, Цахимын багц хуулийн хэрэгжилтийг хангуулах, тоон гарын үсгийн ач холбогдол, цахим үйлчилгээний давуу талыг сурталчлах ажлын хүрээнд Ховд аймгийн төвд нээлттэй хаалганы өдрийг 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулж 89 иргэнд үйлчилгээ үзүүллээ.



Улсын бүртгэлийн байгууллагаас иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг цахимаар бүртгэх үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e mongolia.mn/- д 2022 оны 6 дугаар сарын 16-ны өдрөөс нэвтрүүлж энэ талаар иргэдэд мэдээ мэдээлэл хүргэх ажлыг Ховд аймгийн ЗДТГ, ИТХ-ын албан ёсны сайтууд болон сумдын бүртгэгч нараар дамжуулан хүргэсэн.

Аймгийн Татварын хэлтэстэй хамтран ажиллаж Үйлчилгээний зааланд Киоск машин байршуулан иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.



Мөн иргэдэд E-Mongolia системээс өөрт хэрэгтэй лавлагаа үйлчилгээг хэрхэн авах талаар өдөр тутам мэдээлэл хүргэн ажиллаа.



10. Бусад үйл ажиллагаа

2022 оны улсын төсвийн санхүүжилтээр баригдаж буй хэлтсийн барилгын газрыг дахин шинээр шийдвэрлүүлсэн.



Барилгын явцтай 10 хоног тутам танилцаж, холбогдох инженер техникийн ажилтнуудтай байнгын холбоотой ажиллаа.

Барилгын ажил 2022 оны 11 сарын 01-ны байдлаар 75%-тай зогссон. Гүйцэтгэгч компани, ХЗДХЯ-тай 2023 онд үргэлжлүүлэн ажиллах гэрээ хийгдсэн.



Мөн Хайрлая-Хүндэлье, Хандлагаа өөрчилье, Өөрчлөлтийг өөрөөсөө аяны хүрээнд иргэдэд мэдээлэл өгөх, сургалт сурталчилгаа хийх зэрэг 598 иргэнд “Нөлөөллийн арга хэмжээ”-г авч хэрэгжүүлсэн.

Дээрхи ажлын хүрээнд ИУБ-ийн тасгийн улсын бүртгэгч нар хэлтсийн албан хаагчдын эцэг эх, үр хүүхдүүдийн дунд “Ээждээ хүргэх сэтгэлийн үг”, “Аав ,ээж, хүү, охиндоо хүргэх сэтгэлийн хариуг” захидалаар дамжуулан хүргэх арга хэмжээг зохион байгуулан, хайрлах хүндлэх сэтгэлийн илэрхийлэлийг бид хэзээ хэндээ өгөх, бие биенээ хэрхэн хайрлах хайрыг түгээж амьдрах маш чухал гэдэг ойлголт өгсөн нь ажилтан албан хаагчдын гэр бүлийн дунд чухал ажил болсон..



Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн бүртгэгчид хамтран “Хайрлая хүндэлье, хандлагаа өөрчилъе, өөрчлөлтийг өөрөөсөө” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд “ИХ БУЯН” худалдааны төвийн лангуу түрээслэгч иргэд болон үйлчлүүлж буй 426 иргэдэд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар заавар зөвлөгөө өгч гарын бэлэгтэй нэг өдрийн арга хэмжээ зохион байгуулан ажиллаа.



“Илүүдэл жингүй -Эртэч монгол” аянд нэгдэж хэлтсийн нийт ажилтан албан хаагчдын дунд “Өглөөний гитнастик хийх”, “Ажлын байрны дасгал хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх зэрэг арга хэмжээг тус тус зохион байгууллаа.



Жендерийн үндэсний хорооноос Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилго бүхий “Харилцан хүндэтгэе” аянд Ховд аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон нэгдэж “Иргэний улсын бүртгэлийн тасаг” “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг” Хуулийн этгээдийн улсын бүртгэгч нар хэлтсийн хамт олон, ажилчдынхаа гэр бүл, иргэд үйлчлүүлэгчид рүү чиглэсэн олон талт нөлөөллийн арга хэмжээ зохион байгууллаа. Дээрх аяны хүрээнд нийт албан хаагчдын дунд “Ажлын байрны дасгал хөдөлгөөн” “Өглөөний цай өглөөлөг” зэрэг үйл ажиллагааг тус тус зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд 2006 онд төрсөн 16 нас хүрч буй 2123 хүүхдүүдийн нэрсийг сум багаар гаргаж сумдын улсын бүртгэгч нартай хамтран урилга хүргүүлэн хуулинд заасан хугацаандаа ирж биеийн давцахгүй өгөгдлийн /гар хурууны хээ/ бүртгэлдээ хамрагдан цахим үнэмлэхээ авах талаар сурталчилгаа зохион байгууллаа. Мөн аймгийн төвийн ЕБС-ийн сургуулийн нийгмийн ажилтантай хамтран цахим үнэмлэхээ хуулийн хугацаандаа захиалан зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сурагчдад соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

Дээрх ажлын хүрээнд иргэний улсын бүртгэлийн төрсний бүртгэлийн мэдээллийн санд эцэг эхийн мэдээлэл нь тусгагдаагүй, архивын нотлох баримтанд зөрүүтэй 209 иргэнд холбогдох бүртгэлд засвар өөрчлөлт оруулахаар хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд тусгуулан зөрчлийг нь арилган ажиллалаа.

Хаягжуулалтын тухай хуулийн дагуу Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай хамтран сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор шинээр олгосон хаягуудыг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд тусгах ажлыг сумдын улсын бүртгэгч нартай хамтран зохион байгуулсны дагуу Жаргалант

сум, Булган сум, Эрдэнэбүрэн, Зэрэг, Ховд сумын шинэ хаягуудыг нотлох баримтын хамт албан тоотой хүргүүлэн мэдээллийн санд тусгуулсан.

Мөнххайрхан сум, Ховд сум, Эрдэнэбүрэн, Чандмань, Манхан, Дуут, Мөст, Үенч, Булган, Алтай сумын улсын бүртгэгч нар хөдөөгийн багуудын хурлаар иргэдэд улсын бүртгэлийн байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажлууд, 2022 онд биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хамрагдах 16 нас хүрч буй хүүхдүүд, 25, 45 насны сунгалт хийлгэх иргэдэд хуулийн хугацаандаа бүртгэлдээ хэрхэн хамрагдах талаар тус тус мэдээлэл өгснөөр торгуулийн арга хэмжээнд орох иргэд багассан.

Хэлтсээс иргэний улсын бүртгэлийн багц хууль журмын танилцуулгатай 1650 ширхэг боршур гарын авлага шинээр хийж иргэдэд мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.



“Андгай өргөх ёслол” зохион байгууллаа

Монгол улс анхдугаар үндсэн хуулиа баталсаны 98 жилийн ой, улс тунхагласны баяраар аймгийн 16 нас хүрч иргэний үнэмлэх авч байгаа өсвөр үе, залуучуудыг “Иргэний андгай “өргүүлэн, түүх, соёлоо дээдэлсэн, эх оронч үзэлтэй, үүрэг хариуцлагаа ухамсарласан иргэн болгон төлөвшүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын төлөөлөл 250 сурагчдыг оролцуулан “Монгол улсын иргэний андгай өргөх ёслол”-ын арга хэмжээг зохион байгууллаа.

Дээрхи арга хэмжээг аймгийн ИТХ, Засаг даргын тамгын газар, Хүүхэд залуучууд гэр бүл хөгжлийн газар, Ховд аймгийн залуучуудын холбоотой хамтран зохион байгууллаа.



Ахмад настны өдрийг тэмдэглэн өнгөрүүлсэн тухай

Тус хэлтсээс 6 ахмад ажилтан өндөр насны тэтгэвэрт гарсан бөгөөд ахмадын өдрөөр хэлтсийнхээ ахмадуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн.


Мөн хэлтсийн ажилтнуудтай уулзалт зохион байгуулж тэдний санал бодлыг сонсож ажилладаг.



МУ-д бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 82 жил Бүртгэлийн ажилтны өдөр тэмдэглэн өнгөрүүлсэн тухай

МУ-д бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 82 жил, бүртгэлийн ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлж иргэдэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээнүүдийг авч ажиллаа.

Энэ жилийн хувьд Тоон гарын үсгийн хамралтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх, иргэдэд мэдээлэл түгээх, соён гэгээрүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, ЭХЭУБ-ийн хувийн хэргийг мэдээллийн санд шалгах, “Иргэдэд ээлтэй- бүртгэлийн үйлчилгээ” зэрэг “Бүтээлч ажлын 7 хоног”-ийг зохион байгуулж Бүсийн оношилгоо эмчилгээний төв, ХААН банк, Голомт банкуудтай хамтран ажиллаж тухайн байгууллагын ажилтнуудад мэдээлэл өгч, үйлчилгээ авч буй иргэдэд ТГҮ олгож ажилласан бөгөөд нийт 478 иргэдийг нөлөөллийн арга хэмжээнд хамрууллаа.



Мөн хэлтсийн нийт ажилтнуудад 1 өдрийн сургалт хийж, хөдөө сумдад ажиллаж буй ажилтнуудад мэдээ мэдээлэл өгч, цаашид анхаарч ажиллах зарим асуудлын тухай танилцуулж, байгууллагын аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээнийг бооцоотой зохион байгуулж, баярын хүлээн авалтын арга хэмжээг хамтын хуримтлалын санхүүжилтээр хийлээ.





Уг арга хэмжээгээр салбар, байгууллагын шагнал, аймгийн шагналуудаар ажилдаа амжилт гаргасан албан хаагчдыг шагнаж урамшууллаа.



Хэлтсийн хамт олон “Тэрбум-мод” аяны хүрээнд хэлтсээрээ тайлант оны 10, 5 дугаар саруудад 150ш мод тариллаа.



ЦААШИД ТАВИХ ЗОРИЛТЫН ТАЛААР:

- ✚ Тоон гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.
- ✚ Авлигаас ангид байх, хяналтыг сайжруулах
- ✚ Хүний нөөц сургалтын системд байршуулсан бүхий л хичээлийг тухай бүрд нь судлах
- ✚ ТАХ бүр ажлын байрны сахилга хариуцлагыг өндөржүүлж, үр бүтээлтэй, иргэдэд ээлтэй, ёс суртахуунтай төрийн үйлчилгээг үзүүлэхийг чухалчлах.
- ✚ Монгол бичгийн мэдлэгээ улам сайжруулах

ТАЙЛАН БИЧСЭН: ХЭЛТСИЙН ДАРГА

С.ХОРОЛСҮРЭН